



## “ШИНЭ ХАРХОРУМ”

ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /КОНЦЕПЦ/ –ЫГ  
БОЛОВСРУУЛАХ ОЛОН УЛСЫН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД  
ОРОЛЦОГЧДЫН БҮТЭЭЛИЙГ ДҮГНЭХ ШҮҮГЧДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
УДИРДАМЖ

### ЗОРИЛГО

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас Орхоны хөндийд "Шинэ Хархорум" байгуулах тухай шийдвэр гарсан. Орхоны хөндий нь Монголын эзэнт гүрний түүх, археологийн үнэт олдвортой тул ЮНЕСКО-ын дэлхийн өвд бүртгэгдсэн чухал байршил юм. Энэхүү гайхамшигт төслийг төлөвлөхийн тулд 3-р сарын 18-аас 4-р сарын 15-ны хооронд хот төлөвлөлтийн үзэл баримтлал боловсруулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан. Тус сонгон шалгаруулалтад ирүүлсэн бүтээлийг үнэлэх үүрэг бүхий мэргэжлийн шинжээчдийг шүүгчдийн бүрэлдэхүүнд оролцохыг урьж байна.

### ХУГАЦАА

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ  
ЗАРЛАХ ХУГАЦАА

2024.04.22

11:59 AM

2024.05.21

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ  
ЭЦСИЙН ХУГАЦАА

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ  
ДҮГНЭХ ХУГАЦАА

2024.05.24

11:59 AM

2024.07.29 – 07.31

ШҮҮГЧЭЭР АЖИЛЛАХ  
ХУГАЦАА


Дээрх цагийн хуваарийг UTC+8 /Ulaanbaatar city/ цагийн бүсээр тооцно.

### ОРОЛЦОГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- Дотоодын болон гадаадын хувь хүнд нээлттэй.
- Нийт 6 гишүүнийг сонгон шалгаруулах бөгөөд дараах чиглэлийн хүмүүсээс тус тус нэгийг шалгаруулна. (нас, хүйс, шашин шүтлэг харгалзахгүй)
  - Хот төлөвлөгч
  - Архитектор
  - Байгаль орчны төлөвлөлтөөр дагнасан хот төлөвлөгч
  - Эдийн засагч (Хот төлөвлөлт)
  - Хот төлөвлөлтийн эрдэмтэн (Профессор)
  - Дэд бүтцийн инженер (Дулааны инженер, цахилгааны инженер, ус хангамж, ариутгах татуургын инженер, мэдээлэл холбооны инженер)
- Оролцогч нь "Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал (концепц)–ыг боловсруулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтад оролцож байгаа баг, байгууллагын бүрэлдэхүүнд эсвэл зөвлөхөөр оролцоогүй байх;

### МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ

- Сонгон шалгаруулалтад оролцогчид дараах материалын бүрдлийг файлаар (\*.pdf) цахимаар ирүүлнэ.
  - Хувь хүний танилцуулга
  - Мэргэжлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын туршлага (CV)
- Материалыг "Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны албан ёсны [office@kharkhorum.gov.mn](mailto:office@kharkhorum.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.



ХОЛБОО БАРИХ:

Холбоо барих: 976-77711220  
И-мэйл: [office@kharkhorum.gov.mn](mailto:office@kharkhorum.gov.mn)